



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 11274

Мөрөн сум

Шугам сүлжээний ажлыг хүлээж
авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6, Засгийн газрын 2020 оны 246, 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн “Мөрөн сумын 13 дугаар багт цахилгаан дамжуулах агаарын шугам татах” ажлыг хүлээж авах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Энхжаргал
(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:
Г.Даваадорж (Хөвсгөл Эрчим Хүч ХХК-ийн ерөнхий инженер)
Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)
Ж.Нацагдорж (Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч, Хошууч)
Ч.Баярсайхан (Хөвсгөл барилга захиалагчийн төвийн хяналтын инженер)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:
О.Гэрэлээ (“Трюю Повэр” ХХК-ийн инженер)
Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:
Б.Үүрийнцолмон (“Цолмон Инженеринг” ХХК-ийн Ерөнхий инженер)
Ашиглагч байгууллагын төлөөлөл:
Г.Даваадорж (Хөвсгөл Эрчим Хүч ХХК –ийн ерөнхий инженер)

Комиссын нарийн бичгийн дарга:
Э.Аззаяа (Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн)

2. Барилгын ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, Барилга, хот байгуулалтын яамны сайдын зөвлөмж, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын зөвлөмж, коронавируст халдварт (ковид-19)-аас урьдчилан сэргийлж, халдварт хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 8 дугаар

сарын 31-ний өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Барилгын ажлыг хүлээж авахтай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Э.Азаяа)-д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга, байгууламжийн ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН